



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/353

Бсонибулаг

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27^{1.2} дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалт, 32.1.10 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны А/165 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад орон нутгийн төр захиргааны байгууллагууд, малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэж, тогтоосон хугацаанд зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Вакцин биобэлдмэл, халдвар хамгааллын хувцас, халдваргүйтгэлийн бодисыг хугацаанд нь татан авч хуваарилах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үр дүнг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР